



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

Нийслэлийн хүн амд мэс заслын тусламж,  
үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын  
үйлчлэх хүрээг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн хүн амд мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын үйлчлэх хүрээний хуваарийг хавсралтаар баталсугай.
2. Нийслэлийн хүн амд үзүүлэх мэс заслын тусламж, үйлчилгээг нэмэлт төлбөргүйгээр үзүүлэхийг хувийн хэвшлийн эмнэлгийн дарга, удирдлагуудад даалгасугай.
3. Хавсралтад заасан хуваарийн дагуу нийслэлийн хүн амд мэс заслын лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэхийг Улсын нэгдүгээр төв эмнэлэг /Б.Бямбадорж/, Улсын хоёрдугаар төв эмнэлэг /Б.Баясгалан/, Улсын гуравдугаар төв эмнэлэг /Ц.Төмөр-Очир/-т тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 209 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Ламбаа/-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080239



Тусламж, үйлчилгээний төрөл	Дүүргийн нэр								
	Баянгол	Баянзүрх	Багануур	Багахангай	Налайх	Сонгино хайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй
Мэс заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага	“Номун” эмнэлэг	Батлан хамгаалах, хууль сахиулах албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	Багануур эрүүл мэндийн төв	Батлан хамгаалах, хууль сахиулах албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	Налайх эрүүл мэндийн төв	“Мишээл” эмнэлэг	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	“Мишээл” эмнэлэг	“Номун” эмнэлэг
Лавлагаа тусламж үзүүлэх эрүүл мэндийн байгууллага	Улсын гуравдугаар төв эмнэлэг		Улсын нэгдүгээр төв эмнэлэг		Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Улсын гуравдугаар төв эмнэлэг			Улсын нэгдүгээр төв эмнэлэг